



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 1/307

Улаанбаатар хот

Дүүргийн нутаг дэвсгэрт гудамж нэршүүлэх,
санал боловсруулах комиссыг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар “Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”, MNS5283:2022 “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага” стандарт хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дүүргийн нутаг дэвсгэрт хот, суурин газрын гудамж талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах” үүрэг бүхий Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт гудамж нэршүүлэх, санал боловсруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүүргийн нутаг дэвсгэрт гудамж нэршүүлэх, санал боловсруулах комиссын хурлыг зохион байгуулж, санал боловсруулах, үр дүнг тухай бүрд тайлагнаж ажиллахыг Комиссын даргад үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухай бүр дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Тамир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010875